


Ипотекийн зээлийн тайлан

2016 оны 4 дүгээр сар


Банкууд 2016 оны 4 дугаар сард нийт 1500 зээлдэгчид 89.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3633.0 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 82320-д хүрчээ. Тайлант сард 5%-ийн хүүтэй 18.6 тэрбум төгрөгийн зээлийг 397 зээлдэгчдэд олгосон бол 8%-5% руу 106 зээлдэгчдийн 3.9 тэрбум төгрөгийн зээлийг шилжүүлжээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 0.4 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 17.3 нэгж хувиар тус тус буурч 17.9 хувьд хүрсэн байна.



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.7 хувь буюу 2751.3 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог

бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 5 болон 8 хувийн хүүтэй зээл, 5 болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 22.5 хувь буюу 818.8 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.7 хувь буюу 62.9 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



2016 оны 4 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэлийн 98.9 хувь нь төгрөгийн зээл, 1.1 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 3.1 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.1 байна.




Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 9.2 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар буурсан байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 59.9 сая төгрөг байна.

Тухайн сард 28.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өсчээ.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 86.4 хувь буюу 77.6 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 13.6 хувь буюу 12.2 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1500 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1253 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 241 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2016 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 82320 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 59001 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд (үүнээс 646 нь 5 хувийн хүүтэй зээлд, 646 нь 8 хувиас 5 хувь руу шилжсэн зээлд хамрагджээ), 21003 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2316 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 3.0 сараас 30 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.1 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн

дундаж хугацаа 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 16.7 жил байна.


Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 54.2 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. Харин нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.9 хувь нь 16-20 жил, 17.0 хувь нь 11-15 жил, 9.1 хувь нь 6-10 жил, 0.9 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

Ипотекийн зээл, хугацааны ангиллаар



Зээлийн хүү

Банкуудын 2016 оны 4 дүгээр сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.2 хувь болжээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү буурсан нь банкууд 5 хувийн хүүтэй зээл олгож эхэлсэнтэй холбоотой юм. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 8.4 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 14.1 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2008	12	217,977.5		8.4	19.8	16,522	
2009	12	226,040.6		8.6	18.7	16,784	
2010	12	333,776.6		9.6	16.0	16,700	
2011	12	669,662.8		12.9	14.8	26,869	
2012	12	845,204.4		13.0	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	16.1	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	16.2	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	16.1	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	15.9	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	16.0	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	15.8	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	15.2	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	15.7	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	15.6	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	15.5	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	15.8	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	16.2	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	16.7	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	16.3	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	16.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	16.5	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	16.6	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	16.4	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	16.4	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	16.1	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	16.3	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	16.2	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	16.8	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	16.4	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6	16.7	8.8	77,105	55,830
2016	1	3,434,849.9	2,595,234.1	16.3	10.1	77,226	56,031
	2	3,459,596.6	2,623,837.0	16.6	9.2	77,673	56,577
	3	3,565,321.5	2,679,829.3	17.1	8.8	81,015	57,659
	4	3,632,982.1	2,751,292.4	16.1	8.2	82,320	59,001

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 4 дүгээр сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа (жилээр)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,784,663.6	76.65	2,142,360.0	77.87	16.5	9.6	55526	41,109
2 Дархан-Уул	118,776.8	3.27	100,184.8	3.64	17.9	6.2	3499	2,944
3 Орхон	115,391.4	3.18	94,550.2	3.44	16.8	6.3	3036	2,528
4 Дорноговь	75,018.8	2.06	58,164.6	2.11	17.1	6.8	2185	1,686
5 Дорнод	54,227.4	1.49	43,806.3	1.59	16.9	5.9	1740	1,486
6 Сэлэнгэ	48,776.5	1.34	35,953.5	1.31	14.6	7.4	1693	1,107
7 Увс	48,652.0	1.34	30,267.4	1.10	18.1	6.9	1576	821
8 Өвөрхангай	45,935.3	1.26	29,775.9	1.08	18.8	6.5	1628	837
9 Өмнөговь	42,135.7	1.16	29,562.5	1.07	16.9	6.9	1173	803
10 Ховд	39,943.6	1.10	26,652.2	0.97	18.5	5.4	1312	930
11 Баянхонгор	30,629.2	0.84	21,717.8	0.79	16.7	6.8	951	676
12 Сүхбаатар	29,330.9	0.81	19,004.5	0.69	17.9	5.5	991	566
13 Архангай	27,841.7	0.77	18,269.4	0.66	19.8	5.9	818	523
14 Баян-Өлгий	24,296.3	0.67	11,306.6	0.41	11.9	12.0	1148	326
15 Хөвсгөл	21,742.8	0.60	9,476.7	0.34	11.5	7.3	859	241
16 Говь-Алтай	21,686.5	0.60	15,431.2	0.56	16.6	7.7	711	488
17 Завхан	21,278.5	0.59	11,703.6	0.43	13.4	7.1	780	319
18 Хэнтий	19,830.9	0.55	13,034.1	0.47	18.4	5.0	600	427
19 Төв	18,833.8	0.52	11,357.0	0.41	14.9	5.9	595	330
20 Дундговь	16,823.8	0.46	11,248.6	0.41	15.0	5.8	558	338
21 Булган	14,332.5	0.39	6,519.9	0.24	17.1	6.2	512	182
22 Говьсүмбэр	12,833.9	0.35	10,945.6	0.40	23.4	5.0	429	334
Нийт	3,632,982.1	100.00	2,751,292.4	100.00	16.7	8.8	82320	59001

2016 оны 4 дүгээр сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.7 хувийг Улаанбаатар хотод, 23.3 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.0 хувь буюу 118.8 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 13.6 хувь буюу 115.4 тэрбум төгрөг Орхон аймагт, 8.8 хувь буюу 75.0 тэрбум төгрөг Дорноговь аймагт ноогдож байна.